



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/128

Бат-Өлзий сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бат-Өлзий сумын төвийн сайжруулсан зам засварын ажлын гүйцэтгэлийг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Орхонтуул (Засаг даргын орлогч)
Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)
Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)
И.Маралмаа (Газрын даамал)
Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Зам засварын ажлын гүйцэтгэлийг хянан үзэж, акт үйлдэн хүлээн авч танилцуулахыг ажлын хэсгийн дарга (Н.Орхонтуул)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН